

ХЯТАДЫН ОНМХ-ҮҮДИЙН КОНВЕРГЕНЦИЙН ҮЗЭГДЭЛД
ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Ү.Тианбао (Wu Tianbao, БНХАУ)*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: конвергенц, олон нийтийн мэдээлэл, мэдээллийн шинэ технологи.

Мэдээллийн шинэ технологийн хөгжил нийгмийн амьдралын олон салбарт томоохон өөрчлөлт, шинэчлэлийн эх суурийг тавьж, гэрээсээ гарахгүйгээр дэлхийн аль ч улс оронтой мэдээлэл солилцож, арилжаа наймаа хийж, цахим сургалтад оролцож, мэдлэг боловсролоо дээшлүүлж, мэргэжил эзэмшиж, ямар нэг мэдээллийг хоромхон зуур хүлээн авах боломж бүрдсэн байна. Энэ нь олон нийтийн мэдээллийн өдөр тутмын практикт шинэ нэр томъёо, ухагдахууныг авчирсан бөгөөд сэтгүүлчийн оюун бодол болон практикт нөлөөлж, мэдээллийн агуулга ба хэлбэрт тасралтгүй өөрчлөлт өрнүүлэхэд хүргэжээ. Сүүлийн үед Хятад улсын монгол хэлээрх олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн ашиглаж байгаа техник технологийн нэгдэл ба цацаж байгаа олон нийтийн мэдээллийн агуулга, хэлбэрийн конвергенцийн үйл явц эрчимтэй өрнөжээ.

“Орчин үед интернэт нь олон нийтийн мэдээллийн харилцааны түүхэнд урьд өмнө үзэгдэж байгаагүй хурдаар олон нийтийг байлдан дагуулж байна” (Зулькафиль, 2016). “2022 оны 8 сарын 31-ний өдөр “Хятадын интернэ-

тийн мэдээллийн төв”-өөс гаргасан “Хятадын интернэтийн хөгжлийн байдлын статистик тайлан”-д 2022 оны 6-р сарын байдлаар, Хятадын интернэт ашиглагчид 1,051 тэрбум хүрсэн бөгөөд нийт иргэдийн 74,4% нь интернэтэд хамрагджээ. Гар утсаар интернэт ашиглагч 1,047 тэрбумд хүрсэн нь нийт интернэт ашиглагчийн 99.6%-г эзэлж байгаа” (CNNIC, 2022) гэж дурджээ. Мөн 2022 оны 5 сарын 16-ны өдөр Хятадын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс гаргасан “Хятадын сэтгүүл зүйн хөгжлийн байдлын тайлан”-д тэмдэглэснээр интернэтээс мэдээ хүлээн авагчдын тоо сүүлийн жилд жил дараалан нэмэгдэж, 2022 оны эхний байдлаар 771 саяд хүрч, интернэтээр хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа байгууллага 3208 байгаа” (CJA, 2022) ажээ. Хятад улсын олон нийтийн мэдээллийг монгол хэлээр түгээх ажилд интернэтийг шуурхай ашиглаж эхэлсэн нь конвергенцийн үйл явц эрчимтэй өрнөх үзэгдэл бий болсны илрэл мөн.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн конвергенцийн тухай хамгийн анх Америкийн мэдээлэл зүйн эрдэмтэн Пүвил 1983 онд “Чөлөөт техник мэргэжил” хэмээх номдоо “Дамжуулгын хэлбэрийн конвергенц” гэж дурдав. Америкийн сэтгүүл зүй судлаач Эндрю

Накисон “Цаасан хэвлэлийн, дуун давтамжийн, зурагт давтамжийн, харилцааны хэрэгслийн зохион байгуулалтын, байлдах бодлогын ба ажиллагааны соёлын холболт” (Сай Үөн, 2005) хэмээх ухагдахууныг тайлбарлаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн конвергенцийн шинж чанарыг дүгнэж байлаа. МУИС-ийн профессор, доктор (Sc.D) М.Зулькафиль “Конвергенц хэмээх нэр томъёо шинжлэх ухааны бараг бүх салбарт байдаг түгээмэл зүйл юм. Бүх тодорхойлолтод байдаг нийтлэг зүйл бол өөр өөр төрлийн объектууд янз бүрийн шалтгааны улмаас ойртох үйл явц юм” (Зулькафиль, 2016) хэмээн тодорхойлсон байдаг. БНХАУ-ын Цинхуа Их Сургуулийн профессор Пэн Лан (彭兰) “ОНМХ-үүдийн конвергенцийн үйл явцын дүнд “Фашэн /fusion/ медиа” бүрэлдэж байна. Энэ нь мэргэжлийн ажиллагааны хэв загвар ба арга бодлого, даруй мэдээллийн хэрэгслийн бүхий л арга тохироо сувгийг ашиглан мэдээллийн цогц системийг бүрдүүлнэ” (Пэн Лан) гэж тэмдэглэжээ.

2014 онд ХКН-ын Төв Хороонд “Бүх чиглэлийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэхийг удирдах баг”-ын IV хуралд “Уламжлалт медиа ба шинэ мэдээллийн хэрэгслийн конвергенцийн үйл явцыг ахиулан жолоодох санал”-ыг хянан баталжээ. Хуралд уламжлалт ба шинэ мэдээллийн хэрэгслүүдийг агуулга, хэлбэр, зохион байгуулалтын хувьд нийлэн нэгдэхийг эрчимжүүлж, ирээдүйн хөгжлийг төлөвлөөд тодорхой шаардлагыг дурджээ. Энэ нь Хятадын ОНМХ-үүдийн конвергенцийн үзэгдэл буюу Хятад улсын монгол хэлээрх ОНМХ-үүдийн конвергенцийн үзэгдэл үүсэхэд улс төрийн талаас түлхэц болж байгаагийн бодит жишээ мөн.

Хятад улсын монгол хэлээрх олон ОНМХ-үүдийн конвергенцийн үзэгдэл бий болсныг судлахад түүний хөгжлийн хэв маягийг ажиглаж, Хятад улсын бодит байдал ба дэлхийн сэтгүүл зүйн их орчинд суурилан задлан шинжилж, онцлог шинжийг нь хураангуйлан өгүүлье.

Нэг. Зохион байгуулалтын нэгдэл. Дэлхий дахинд хэвлэл мэдээллийн зохион байгуулалт, медиа компанийн конвергенц нь XIX зууны сүүлчээс эхэлжээ. Үүний суурин дээр хэвлэлийн бүлэг бий болж, XX зууны 30-аад оны үед нөлөөлөх шинж нь илэрч эхэлжээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараа хэвлэлийн бүлгийн хамрах хүрээ нь улам өргөжиж, олон улсын хэмжээ-ний том хэвлэлийн бүлэглэл гарч иржээ. Хятад улсын дотоодын хэвлэлийн зохион байгуулалтын нэгдэн нийлэх үйл ажиллагаа нь ХКН-ын санаа-чилга ба удирдлагаар явагдаж ирсэн бөгөөд “2014 оныг Хятад улсын ОНМХ-үүдийн конвергенцийн эхний жил гэж үздэг” (Зээ Жишэн, 2015).

Энэхүү ОНМХ-үүдийн конвергенцийн үйл ажиллагааг өрнүүлэх шалтгаан нь дэлхийн олон нийтийн мэдээллийн даяаршлын үед Хятад улсын үндэсний уламжлалт соёлоо өвлөн үлдээх ба гадаад улс оронд Хятад улсын өнөөгийн байдал, түүхийн уламжлалт соёлыг зөв ойлгуулах, шуурхай мэдээлэл хүргэх үйл ажиллагаандахь ОНМХ-ийн үүргийг гүйцэд биелүүлэн, өрсөлдөх хүчээ олон улсын хэмжээнд дээшлүүлэхийн төлөө юм. Хятад улсын хэвлэлийн бүлэг хөгжлийн замын анхны гарааг эхлүүлсэн нь “Гуанжу өдрийн сонин” (1996 он) бөгөөд өдгөө Хятад улс даяар 57 хэвлэлийн бүлэглэл үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр бүлэглэл үүсэхэд сүүлийн жилүүдэд Хятад улсын дотоодын

хэвлэлийн зохион байгуулалт, хэвлэлийн нэгж байгууллага ба медиа компанийн өндөр түвшний нэгдэн нийлэлт чухал үүрэгтэй байжээ. Хятад улсын монгол хэлээрх ОНМХ-үүдийн конвергенцийн үйл явцыг нэг багийн зохион байгуулалтын буюу дотоодын конвергенц, өөр зохион байгуулалт буюу компанийн хоорондох конвергенц гэж хоёр янзаар ойлгож болно.

Өвөр Монголын ОНМХ-үүд 2009 оноос эхлэн конвергенцийн үйл ажиллагааг эрчимтэй эхлүүлжээ. Монгол радиогийн нэгдэл нь 2009 оны 11 дүгээр сарын 19-нд эхэлж, “Өвөр Монголын ардын радио хорооноос уриалан ӨМӨЗО-ны бүх 12 аймаг, хотын радио хороо болон Манжуур, Эрээн хот хамтран нэгдэн нийлэх үйл явцыг гүйцэтгэсэн байна. Энэхүү нэгдэл нь хамтран ашиглах 5 платформтой” (“Өвөр Монголын мэдээ”, 2017) ажээ.

2011 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Өвөр Монголын Монгол сонины нэгдэл Хөх хотод байгуулагдав. Энэ нь 12 сонин, 5 сүлжээ гишүүнтэй, 1 интернэт порталтай юм. Мөн 2013 онд дижитал платформыг байгуулжээ. Түүнчлэн 2013 онд Хятад улсын Сонин мэдээ радио телевизийн хорооны шийдвэрээр Өвөр Монголын Одон телевиз болон 10 аймаг хотын радио телевиз тус тусдаа нэгдэл байгуулжээ. Эдгээрийн хооронд мэдээ мэдээллийг хамтдаа хуваалцах, ажлын туршлага солилцохын сацуу алсын хараа нэгтэй

урагшилж, хамгийн их үр ашгийг гаргаж, эрх тэгшээр хамтрах эцсийн зорилгодоо хүрэхийг чармайн ажиллаж байна.

Өнөөгийн монгол хэлээрх ОНМХ-үүдээс ойролцоо шинжтэй нь конвергенцийн үйл явцыг илүү ихээр өрнүүлж байгаагаас гадна, хамтарч болох бүх чиглэлээр мэдээллийн хүчтэй харилцаа тогтоож байгаа нь ажиглагддаг. 2017 онд “Өвөр Монголын өдрийн сонин” ба

ардын “Өдрийн сонин”-ууд нэгдэн “Далан хар” сүлжээг байгуулж, хамтын бүтээл бий болгох үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Дэлхийн олон нийтийн мэдээллийн даяаршлын их орчинд монгол хэлээрх ОНМХ-үүд өөрийн хөгжлийн зөв замыг сонгохын тулд нэгдэн нийлэх конвергенцийн үйл явцыг эрчимтэй өрнүүлэх чухал юм.

Хоёр. дижитал платформ. Өнөөгийн

сэтгүүл зүйд нэвтэрч байгаа мэдээллийн шинэ хэрэгсэл нь сонин, сэтгүүл, радио, телевиз зэрэг уламжлалт мэдээллийн хэрэгслийн хөгжлийн суурин дээр бий болсон компьютер, интернэт, гар утас зэрэг мэдээллийн зуучууд юм. Мэдээллийн шинэ хэрэгсэл нь тоон технологи бөгөөд интернэтэд суурилан компьютер, гар утас, дижитал телевиз зэргээр зууч болгож хүлээн авагчдад мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг.

Орчин үед монгол хэлээрх ОНМХ нь уламжлалт медиа, интернэт медиа гэсэн хоёр хэлбэрээр оршиж, интернэт медиа нь өнөөгийн сэтгүүл зүйн хүрээнд



Өнөөгийн монгол хэлээрх ОНМХ-үүдээс ойролцоо шинжтэй нь конвергенцийн үйл явцыг илүү ихээр өрнүүлж байгаагаас гадна хамтарч болох бүх чиглэлээр мэдээллийн хүчтэй харилцаа тогтоож байна. 2017 онд “Өвөр Монголын өдрийн сонин” ба ардын “Өдрийн сонин”-ууд нэгдэн “Далан хар” сүлжээг байгуулж, хамтын бүтээл бий болгох үйл ажиллагаагаа эхлүүлжээ



яригдах мэдээллийн бүх шинэ хэрэгслийг хамарна. ХКН-ын Төв Хороо, ӨМӨЗО, ӨМӨЗО-ны харьяат аймаг хот ба орон нутаг гэх дөрвөн дэсийн монгол хэлээрх ОНМХ-ийнхэн бүгд интернэт медиагийн ашиглалтыг чухалчилж, уламжлалт мэдээллийн сувгийг интернэтэд байршуулж, гар утасны аппликейшн бүтээн байгуулалтын ажлыг голчлон гүйцэтгэж байгаа нь сүүлийн жилд монгол хэлээрх ОНМХ-ийн системд үүсэж байгаа шинэчлэлийн чухал илрэл ба онцлог юм. Үүнд Вичат, Блог, Tiktok зэрэгт бүгд албан ёсны мэдээллийн сувгаа нээн хөгжүүлжээ.

Хятад улсын сэтгүүл зүйн эрдэмтэд үүнийг ОНМХ-үүдийн конвергенцийн үйл явц бол “хоёр бичил нэг апп”(两微一端)-ыг биелүүлэх явдал хэмээн үзэж сайшаан дэмжиж байна. Өөрөөр хэлбэл, монголоор интернэтэд нэмэх аппликейшн гэж ойлгож болно. ХКН-ын Төв Хорооны хэвлэл “Ардын сонин”-ы монгол хэлний “Ардын сүлжээ” сайттай. Хятад улсын радио хорооны монгол нэвтрүүлэгт “Хятад улсын монгол радио сүлжээ” гэх тусгай интернэт портал байгаа бөгөөд мөн “Хятад улсын монгол радио вичат” ч байдаг. Хятад улсын төв телевизийн хорооноос “Монгол хэлээрх тусгай сувгийн сүлжээ” ажиллуулж, хэрэглэгчдэд монгол хэлээр олон төрлийн нэвтрүүлэг хүргэж байна. Шинхуа хороо бас монгол хэлээрх “Шинхуа сүлжээ”-тэй бөгөөд “сансар” апп ба “Шинхуа Монгол хэлээрх сүлжээ” хэмээх вичаттай. Эдгээр монгол хэлээрх олон улсын стандарт албан ёсны цахим хуудас нь сүүлийн үеийн ОНМХ-үүдийн конвергенцийн дагуу шинээр бий болсон юм.

ӨМӨЗО-ны хэмжээнд интернэт нэмэх аппликейшны загварыг нэлээд сайн гүйцэтгэсэн байдаг. Өвөр Монголын радио телевиз хороонд “Тэнгэрийн

сүлжээ”-г байгуулж, радио, телевизийн бүхий л нэвтрүүлгийг тус сүлжээгээр цацаж, үзэгчдэд нэвтрүүлгийг шуурхай хүлээн авах ба лайв үзэх боломжоор хангасан байна. “Давхиа мэдээ” хэмээх аппликейшныг ажиллуулж, мөн радио, телевизийн бүхий л нэвтрүүлгийг дамжуулж, “Шуурхай мэдээ”, “Тал нутгийн дуун” гэх хоёр албан ёсны вичатыг ашиглаж байна.

“Өвөр Монголын өдрийн сонин”-ы хорооны монгол хэлээрх олон нийтийн мэдээллийг үйлдвэрлэх, түгээх зориулалт бүхий интернэт нэмэх аппликейшны загварын байгуулалт ихээхэн амжилтад хүрчээ. Тус сонины хорооны ажиллуулж байгаа “Хятад улсын монгол сонин мэдээний сүлжээ” нь өнөөгийн байдлаар Хятад улсын монгол хэлээрх ОНМХ-ийн системийн нэртэй брэнд болжээ.

Шинжааны радио хорооны монгол нэвтрүүлэг нь “Шинжааны монгол радио сүлжээ” ба “Шинжааны монгол радио” аппликейшнтай. ӨМӨЗО-ы харьяат аймаг хотууд мөн интернэт нэмэх аппликейшны загвараар хөгжиж байна. Өнөө үед интернэт нэмэх аппликейшны загвараар хөгжихөд дижитал техник технологи гол баталгаа болж, гар утас, аппликейшны онцлогт зохицуулан контент үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж байна.

Гурав. Нэг удаа үйлдвэрлэж, олон сувгаар түгээх. Сүүлийн үед бүх муж орны хэвлэлийн байгууллагууд ХКН-ын “Нэг удаа үйлдвэрлэж, олон сувгаар түгээх” ОНМХ-үүдийн хөгжлийн загварыг баримталж байна. Энэ нь нэг хэвлэлийн байгууллага нэгжид хамрагдах мэдээллийн сувгийн конвергенцийн үйл явцыг шууд урагшлуулах үйлдэлтэй юм. Мэдээллийн эх сурвалжийг цуглуулах, найруулах, үйлдвэрлэх зэрэг

нь тухайн хэвлэлийн байгууллагын ямар нэг баг ба тусгай хэлтсээр дамжин медиа бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүх явцыг гүйцэтгэсний дараа, тухайн байгууллагын ажиллуулж байгаа өөр мэдээллийн суваг, өөр сэтгүүлчийн багт медиа бүтээгдэхүүнээ харилцан хуваалцах тогтолцоогоор үйл ажиллагаа явагддаг. Энэ тогтолцоонд мэдээлэл үйлдвэрлэх явцдаа хүлээн авагчдын хүсэлт, сонирхлыг хангах бодлого баримталдаг онцлогтой юм.

Энэхүү загварын хөгжлийн дагуу хэвлэлийн байгууллагын дотоодод бас “Сонин мэдээний төв” гэдэг хэлтэс шинээр бий болж, энэ нь өмнөх үеэсээ илүү чухал байр суурийг эзэлж, илүү чадавхтай болж өөрчлөгджээ. “Сонин мэдээний төв” нь мэдээний эх материалыг цуглуулах, сурвалжлах, найруулах, нийтлэх ба хүлээн авагчидтай харилцах, санал хүсэлтийг нь хүлээн авах зэрэг бүх үйл явцыг гүйцэтгэх бүрэн боломжийг бүрдүүлж, хэвлэлийн байгууллагын дотоод дахь өөр мэдээллийн сувагтай нягт хамтран ажиллаж байна.

2000 онд дэлхийн ОНМХ-үүдийн конвергенцийн эхлэлийн нэг болох АНУ-ын Флорида (Florida)-гийн “Тампа” сонины мэдээний төв (Tampa’s News Center) байгуулагджээ. Энэ төв нь уламжлалт ОНМХ-үүд ба интернэт медиа бүхнийг нэгэн талбар, ажлын байранд ажиллуулж, хоорондоо хамтран ажиллах ажлын орчныг бүрдүүлэн, эх сурвалж ба бүтээгдэхүүнээ шуурхай хуваалцах нөхцөлийг хангаж, ОНМХ-үүдийн конвергенцийн “Тампа” загвар бий болжээ” (Forrest Carr, 2002). Энэ мэт ОНМХ-ийн хамтын ажиллагааны үр дүнд ажлын бүтээмжийг дээшлүүлэхийг зорилго болгосон “Сонин мэдээний төв”-үүд бий болж, цаашид эрчимтэй хөгжиж эхэлжээ.

2007 онд Хятад улсын Сонин мэдээ, хэвлэлийн яамнаас ОНМХ-үүдийн конвергенцийн системийг бүтээн байгуулах үйл ажиллагааг эхлүүлж, ОНМХ-үүдийн конвергенцийн үйл явцыг урагшлуулахад ихээхэн тус дэмжлэг үзүүлжээ. Яг ийм түүхэн байдалд Хятад улсын уламжлалт медиа ба интернэт медиа нэгдэн нийлж “Сонин мэдээний төв” байгуулснаар олон талын мэдээллийн хүчийг нэгтгэж, мэдээллийн үр ашиг, хүртээмжийг үлэмж сайжруулжээ. 2014 онд Хятад улсын “Ардын өдрийн сонин”-ы хорооны харьяанд медиа компани байгуулагдаж, ОНМХ-үүдийн конвергенцийн бас нэг шинэ эхлэлийг тавьжээ. Хятад улсын төвийн радио “Хятад улсын радиогийн интернэт сурвалжлах, нэвтрүүлэх платформ”-ыг байгуулж, 2015 оны 10 дугаар сард 100 өдрийн сонины бүлэглэлээс байгуулсан “3D сонин мэдээний төв” ашиглалтад оржээ. Сүүлийн жилд Хятад улсын бүх муж оронд “Сонин мэдээний төв”-ийн бүтээн байгуулалт эрчимтэй хөгжиж байна.

Хятад улсын монгол хэлээрх ОНМХ-ийн конвергенцийн үйл явцтай хамт бий болсон “Сонин мэдээний төв” нь ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрт бас олон тоогоор байгуулагджээ. 2015 оны 4 дүгээр сард “Өвөр Монголын өдрийн сонин”-ы хорооны өөрчлөлт эхэлж, 2016 оны 3 дугаар сард уг өөрчлөлтийг амжилттай дуусгаж, “Өвөр монголын өдрийн сонин”-ы хорооны конвергенцийн үйл ажиллагаа амжилттай биелэгджээ” (“Өвөр Монголын өдрийн сонин”, 2016). 2016 онд Өвөр Монголын радио телевиз хорооноос сонин мэдээ үйлдвэрлэх интернэт системийг байгуулжээ. Энэ системд эх материал цуглуулах, боловсруулах, нэвтрүүлэг бэлтгэх, интернэт портал хийх зэрэг хэд хэдэн хэсгээс бүрэлдэж, мэдээллийн

хэрэгслийн конвергенцийн чадавхтай адилхан үйл ажиллагаа явуулдаг болсон юм. ӨМӨЗО-ны орон нутгийн хэвлэлийн байгууллага мөн “Нэг удаа үйлдвэрлэж, олон сувгаар түгээх” ОНМХ-үүдийн конвергенцийн чадавхыг идэвхтэй ашиглаж байна.

Дөрөв. Өөрийн брэндийг бий болгох. Өрнө дахины хөгжсөн улс орны сэтгүүл зүйн хөгжлийн түүхээс харахад тэд олон улсын хэмжээний медиа брэндтэй байдаг. Энэ нь дэлхий дахинд нөлөөллөө нэмэгдүүлэх чухал арга хэмжээ бөгөөд цаашдын хөгжлийн эдийн засгийн чухал суурь баталгааг хангадаг байна. BBC радио компани гэхэд л BBC Choice, BBC World Service, BBC Online зэрэг медиа брэндтэй бөгөөд BBC iplayer гэх видео үйлчилгээтэй (Зуо Яан & Луг Энвэй. 2013) байдаг нь үүний тод жишээ юм.

Хятад улс медиа брэнд үүсгэх ажлыг ХХ зууны сүүлээс эхлүүлжээ. Энэ нь ХХ зууны 70-аад оны сүүлд Хятад улсад “Өөрчлөлт хийж чөлөөтэй амьдрах” төрийн шинэ бодлого хэрэгжиж, нийгмийн бүх хүрээнд их өөрчлөлт гарсантай шууд холбоотой юм. Энэхүү төрийн бодлого үргэлжлэн явагдахын зэрэгцээ ОНМХ-ийн үйл ажиллагаа нь маркетингийг чухалчилж, хүлээн авагчид нь “хэрэглэгчид” болж хувирах шинж илэрч эхэлжээ.

Хятад улсад бүхий л монгол хэлээрх ОНМХ-ийг харьцангуй цөөн хүн амтай үндэстэн ажиллуулж байх боловч агуулга, хэлбэрийн шинэчлэлийг шуурхай явуулж, тухайн үеийн бодит байдалтай нийцсэн медиа брэндийг бий болгох үйл хэрэгтээ ихээхэн амжилт олсон байдаг. 2017 онд ӨМӨЗО байгуулагдсаны 70 жилийн ойд зориулан “Өвөр Монголын өдрийн сонин” ба төвийн “Ардын өдрийн сонин”-ы хамтран байгуулсан “Далан хар ажиллах

өрөө”-ний интернэт медиагийн чадавхыг гүйцэд таниулж, олон нийтийн таашаалыг хүртсэн бүтээлүүд төрөн гарчээ.

“Өвөр Монголын өдрийн сонин”-ы хорооны “Хөлөг” апп нь Хятад улсын монгол хэлээрх интернэт медиагийн олон бүтээгдэхүүний доторх чухал брэнд болж хөгжжээ. 2018 оны нэгдүгээр сарын 14-ний өдөр “Хөлөг” аппликейшны “Ар хорчин 2018” монгол хэлээрх сүлжээний “Цагаан сарын үдэшлэг”-ийн live-ийг үзсэн хүний тоо 300.000 гаруй болжээ. Өнөөгийн интернэт медиагийн чухал ачаалагч болох гар утас нь олон нийтийн заавал ашиглах мэдээллийн хэрэгсэл болсон. Олон нийтийн гар утасны аппликейшныг ашиглах нэг хэлбэр нь зар сурталчилгаа хийх үйл ажиллагаа бөгөөд агуулга хэлбэрийн шинэчлэлийг үргэлж баримтлах явдал юм. Хятад улсын монгол хэлээрх ОНМХ-ийн системд ихээхэн нөлөөтэй “Хөлөг” апп нь “Тэргүүн мэдээ”, “Анхаарал төвлөрөл”, “Сүлжээн үдэшлэг”, “Онол шүүмж”, “Соёл цэнгэл”, “Онц мэдээлэл”, “Дуу дүрс”, live, “Дижитал сонин” гэх мэт хэд хэдэн тусгай булантай бөгөөд зураг, бичлэг зэрэг уламжлалт мэдээллийн хэрэгслийн бүх хэлбэрийг багтаасан юм.

“Өвөр Монголын өдрийн сонин”-ы хорооны конвергенцийн ерөнхий төлөвлөгөөний **нэгдүгээрт**: техник мэргэжлийн түвшний нэгдлийг биелүүлэх, **хоёрдугаарт**: зохион байгуулалтын нэгдлийг хангах, **гуравдугаарт**: хэвлэлийн бүлэглэлийг байгуулах” (“Өвөр Монголын өдрийн сонин”, 2016) зорилтуудыг багтаасан байдаг. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд “Өвөр Монголын өдрийн сонин”-ы маркетингийг ашиглах, түүнд зохицсон шинэ

бүтээгдэхүүн үйлдвэрлэх, медиа брэндийг үүсгэн байгуулах арга тохироо бүрдэж, зохих түвшний амжилтад хүрсэн байна.

Дүгнэж хэлэхэд Хятад улсын монгол хэлээрх ОНМХ-үүдийн конвергенцийн үйл явцыг зөв хэрэг-жүүлж, ОНМХ-ийн маркетингийг ашиг-лаж медиа брэндийг бий болгох нь чухал юм. Өнөөгийн интернэт, дижитал, 5G зэрэг шинэ технологид суурилан, интернэт медиаг бүрэн төгөлдөр ажиллуулж, олон нийтийн анхаарлыг татаж, таашаалыг олох нь цаашдын хөгжлийн бүрэн баталгаа болж байна.

Эшлэл

1. Зулькафиль. М. 2016. Орчин үеийн медиа : шинэчлэл, чиг хандлага. УБ., х.227.
2. China Internet Network Information Center /CNNIC/. Website: www.cnnic.cn)
3. All-China Journalists Association. Website: www.zgjj.cn
4. Сай Үөн. 2005. Сэтгүүл зүй ба олон нийтийн харилцааны өөрчлөлтийн судалгаа. IX хэвлэл. "Хятадын сэтгүүлч" сэтгүүл.
5. Зулькафиль. М. 2016. Орчин үеийн медиа : шинэчлэл, чиг хандлага. УБ., х.245.
6. Пэн Лан. 2009. Медиа конвергенцийн үеийн дөрвөн чухуул элемент. VI хэвлэл, "Залуу сэтгүүлч" сэтгүүл.
7. Зээ Жишэн. 2015. Хятадын анханы медиа конвергенцийн хөгжлийн хурал. Чиг Доо хот. IX хэвлэл, "Хэвлэл мэдээлэл".сэжтгүүл.
8. 2017. ӨМӨЗО -ы медиа конвергенцийн хөгжлийн судалгаа. "Өвөр Монголын мэдээ" сайт.
9. Forrest Carr. 2002.The Tampa Model of Convergence. www.poynter.org.
10. "Өвөр монголын өдрийн сонин"-ы конвергенцийн үйл явц. "Өвөр монголын өдрийн сонин" сайт, 2016.
11. Зуо Яан., Луг Энвэй. 2013. ВВС-гийн өнөөгийн байдал ба ирээдүй. IV хэвлэл.
12. "Мэдээний зууч".
12. "Өвөр монголын өдрийн сонин"-ы хорооны конвергенцийн төлөвлөгөө. "Өвөр монголын мэдээ" сайт, 2016.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зээ Жишэн. 2015. Хятадын анханы медиа конвергенцийн хөгжлийн хурал. Чиг Доо хот. IX хэвлэл, "Хэвлэл мэдээлэл" сэтгүүл.
2. Зулькафиль. М. 2016. Орчин үеийн медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ.
3. Зуо Яан., Луг Энвэй. 2013. ВВС-гийн өнөөгийн байдал ба ирээдүй. IV хэвлэл. "Мэдээний зууч".
4. "Өвөр монголын өдрийн сонин"-ы конвергенцийн үйл явц. "Өвөр монголын өдрийн сонин" сайт, 2016.
5. "Өвөр монголын өдрийн сонин"-ы хорооны конвергенцийн төлөвлөгөө. "Өвөр монголын мэдээ" сайт, 2016.
6. ӨМӨЗО -ы медиа конвергенцийн хөгжлийн судалгаа. "Өвөр Монголын мэдээ" сайт, 2017.
7. Пэн Лан. 2009. Медиа конвергенцийн үеийн дөрвөн чухуул элемент. VI хэвлэл, "Залуу сэтгүүлч" сэтгүүл.
8. Сай Үөн. 2005.Сэтгүүл зүй ба олон нийтийн харилцааны өөрчлөлтийн судалгаа. IX хэвлэл. "Хятадын сэтгүүлч" сэтгүүл.
9. All-China Journalists Association. Website: www.zgjj.cn
10. China Internet Network Information Center /CNNIC/. Website: www.cnnic.cn)
11. Forrest Carr. 2002.The Tampa Model of Convergence. www.poynter.org.

Summary

This article studies emergence of the phenomenon of convergence of Mongolian-language mass media in China and analyzed its development pattern based on the reality of China and the global journalistic environment, and summarized its features. It also introduces the various factors that affect the development of media convergence and their specific performance in Mongolian media convergence in China.